



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

**Үндэсний сурын харвааны хэрэгсэл болон орчин.
Сургалтад тавих шаардлага.**

MNS 6701 : 2017

Албан хэвлэл

**СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
УЛААНБААТАР ХОТ
2017 он**

Өмнөх үг

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ) нь Олон Улсын Стандартчиллын Байгууллагын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран үндэсний стандартчиллын бодлогыг хэрэгжүүлэх ажил эрхэлдэг.

Стандартын төсөл боловсруулах ажлыг салбарын стандартчиллын Техникийн хороо (ТХ), Дэд хороо (ДХ) эрхлэн гүйцэтгэдэг бөгөөд Техникийн хорооны хурлаар хэлэлцэж гишүүдийн 75%–иас доошгүй дэмжиж, зөвшилцсөн төслийг Стандартчиллын Үндэсний Зөвлөл (СҮЗ)–өөр хэлэлцэн, тогтоолоор баталснаар хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Биеийн тамир, спортын газраас санаачлан Монголын үндэсний сурын холбоо эрхлэн боловсруулсан.

СХЗГ-ын стандартын шинжээч Н.Батжаргал “Монгол улсын стандартчиллын тогтоолын 2-р хэсэг: Стандартын бүтэц ба боловсруулах дүрэм MNS 1-2:2006” стандарттай нийцүүлэн хянав.

Стандартыг Биеийн тамир, спортын стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн болно.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46А

Улаанбаатар 13348, ШХ-48

Утас: 266754, 263860,

Факс: (976-11) 458032

E-mail: standardinform@masm.gov.mn

Вэб сайт: www.estandart.gov.mn,

www.masm.gov.mn

© СХЗГ, 2017

“Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай” Монгол улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын Төв байгууллага)-т байна.

Оршил

Үндэсний сурын харвааны хэрэглэл, орчин болон сургалт, дасгалжуулалтад тавих шаардлагын тухай

Бидний энэ удаагийн боловсруулсан стандарт нь “Үндэсний сурын харвааны хэрэглэл, орчин болон сургалт, дасгалжуулалтад тавих шаардлага”-ыг хамарснаараа илүү өргөн хүрээг хамарсан болно.

Энэхүү стандартаа боловсруулахын тулд дараах үйл ажиллагаануудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Өмнөх(MNS 3285:1990) стандартыг судалж түүний зарим чухал санааг тусгахыг хичээсэн.
2. Нум сум урлаачид болон харваачдаас “Нум, сумны хэмжээний баримжаа тогтоох” судалгаа авах аргачлал боловсруулж, МҮСХ-ны тэргүүлэгчдийн туслалцаатайгаар мэдээлэл цуглуулж, нэгтгэсэн.
3. Нум, сум хийж, урлаж байгаа ахмад, туршлагатай харваачидтай уулзаж хамтран ажилласан.

Түүнчлэн, сурын харвааг олон зууны туршид, үндэстэн, ястан бүр өөр өөрийн олон хувилбартай, уян хатан зохицуулалтайгаар явуулж ирсэн уламжлалтайг харгалзан энэхүү стандартыг хатуу тогтоосон үзүүлэлттэй “эталон” маягаар гаргах нь тийм ч зохистой биш хэмээн үзэж, гол гол тоон үзүүлэлтүүдийг доод, дээд хязгаартайгаар зааж өгөх нь зохистой гэж үзсэний үндсэн дээр урьдчилсан тойм судалгааг үндэслэл болгон авсан.

“Хавсралтууд”-д нэр томъёо болон стандартад орсон гол гол заалтуудтай шууд холбогдох хэрэглэл, талбай, эд зүйлсийн зургийг оруулсан.

Дэмжлэг үзүүлсэн БСШУСЯ, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир спортын газар, тохируулагч агентлаг Стандарт хэмжил зүйн газрын мэргэжилтэнгүүдэд арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлсэнд талархал илэрхийлье.

Эрхэм Та бүхнийг стандартыг цаашид улам сайжруулахад санал бодлоо илэрхийлж, спортыг хөгүүлэх үйлсэд хамтарч ажиллан гэдэгт гүнээ итгэнэм.

Хүндэтгэсэн,

Монголын үндэсний сурын холбооны Хүндэт ерөнхийлөгч С.Батхуяг,
Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Хүрэлбаатар, Тэргүүлэгч Т.Баярмэнд.